



ХӨДӨЛМӨР ЭРХЛЭЛТИЙГ ДЭМЖИХ ТӨСӨЛ

Хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын сургалтын ерөнхий хөтөлбөр, уг ур чадварыг үнэлэх хэрэглэгдэхүүн боловсруулж, сургагч багш бэлтгэх чиглэлээр зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллага сонгон шалгаруулна

Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яам, Дэлхийн банкны зээл, техникийн дэмжлэгтэйгээр ажил хайгч, бичил бизнес эрхлэгч иргэдийн хөдөлмөрийн зах зээлийн боломжийг нэмэгдүүлэх зорилготой “Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих төсөл” хэрэгжүүлж байна. Тус төслийн 2-р бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд “Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт” зохион байгуулах юм. Сургалтын нэг үндсэн зорилго нь сургалтад хамрагдаж буй ажил хайгч иргэдийн хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг дорвитойгоор дээшлүүлэхэд чиглэгдэх болно. Тиймээс ажил хайгчдын хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг нэмэгдүүлэх зорилготой чадамжид суурилсан сургалтын ерөнхий хөтөлбөр боловсруулан батлуулах, хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг үнэлэх хэрэглэгдэхүүн боловсруулан, туршиж бэлэн болгох, Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах сургалтын байгууллагуудын багш нарыг бэлтгэх ажлыг гүйцэтгэх сэтгэл судлалын чиглэлээр үйл ажиллагаа явуулдаг сургалт, судалгаа, зөвлөх үйлчилгээний байгууллага сонгон шалгаруулж, хамтран ажиллана.

Дараах ажлыг гүйцэтгэнэ. Үүнд:

1. Уг ажлыг гүйцэтгэх зорилгоор чанарын болон бага хэмжээний тоон судалгаа хийж, мэдээлэл цуглуулан ажил хайгчдад дутагдаж буй хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын талаар тайлан бэлтгэх,
2. Хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын чадамжид суурилсан сургалтын ерөнхий хөтөлбөр боловсруулан, холбогдох байгууллага, ажилтнуудтай зөвшилцөн эцэслэж баталгаажуулах,
3. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалт зохион байгуулах сургалтын байгууллагуудын хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын сургалтын сургагч багш бэлтгэх 2 өдрийн сургалтын хөтөлбөр, хэрэглэгдэхүүн боловсруулж, сургалт зохион байгуулах,
4. Хөдөлмөр эрхлэлтийн цогц сургалтын нөлөөллийн үнэлгээ, мониторингийн зорилгоор хандлага, төлөвшил, харилцааны ур чадварыг үнэлэх хэрэглэгдэхүүн/сорил боловсруулан туршиж, эцэслэх,

5. Нөлөөллийн үнэлгээний мэдээлэл цуглуулж хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын үнэлгээний хэрэглэгдэхүүн/сорилыг ашиглах судлаачдад зориулсан сургалтын материал бэлтгэж, сургалт зохион байгуулах,
6. Хандлага, төлөвшил, харилцааны ур чадварын сургалтын бататгал болгож гар утасны дуут шуудангаар илгээх мессежний /багадаа 20 мессеж/ агуулга, текст боловсруулах,

Хэрэгжүүлэх хугацаа: Тус зөвлөх үйлчилгээ нь 55 хүн/өдрийн ажил бөгөөд 2019 оны 6 дугаар сараас 10 дугаар сарын 30-ны хооронд нарийвчилсан төлөвлөгөөний дагуу гүйцэтгэнэ.

Зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлага:

- Албан ёсны гэрчилгээ бүхий хуулийн этгээд,
- Хэрэглээний сэтгэл судлал, хүний хөгжлийн зан төлөвийн шинжлэх ухааны чиглэлд амжилттай ажиллаж байгаа туршлагатай,
- Сургалтын хөтөлбөр, модуль, агуулга боловсруулах туршлагатай,
- Холбогдох чиглэлээр сургалтын болон сургалт зохион байгуулж байсан туршлагатай,
- Модульт, оролцоонд тулгуурласан, чадамжид суурилсан сургалтын хөтөлбөр боловсруулах, зөөлөн ур чадварыг хэмжих, үнэлэх чиглэлээр мэдлэг, практик туршлагатай.

Сонгон шалгаруулалтад орох хүсэлтэй байгууллагууд зөвлөх үйлчилгээ үзүүлэх байгууллагад тавигдах шаардлагыг хангаж буйг илэрхийлэх баримт бичгүүд, уг ажлыг хариуцан гүйцэтгэх ажилтнуудын анкетийн хамт mesp@mlsp.gov.mn цахим хаягаар болон Улаанбаатар-15170, Чингэлтэй дүүрэг, 4-р хороо, Макс цамхаг, 701-702 өрөөнд 2019 оны 6 дугаар сарын 10-ны өдрийн 16.00 цагаас өмнө ирүүлнэ үү.

Холбогдох утас: 7700 0784

ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМ